



“МОНГОЛ БАЗАЛЫТ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 03-р сарын 07-ны өдөр

№ 04

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай





Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дах заалтууд, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, “Монгол Базальт” ХК-ийн дүрмийн 6 дугаар бүлгийн 6.2, 6.3, 6.2, 6.4 дах заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:




1. “Монгол базальт” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2023 оны 04 сарын 17-ны өдрийн Даваа гаригийн 14.00 цагт зарлан хуралдуулахаар шийдвэрлэсүгэй.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралдааныг хувьцаа эзэмшигчдийн цаг хугацаа, орон зайнаас хамаарахгүйгээр оролцох боломжийг бүрдүүлж цахим болон танхимын хосолсон хэлбэрээр явуулах бөгөөд Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Фламинго тауэр 7 давхарт, “Монгол базальт” ХК-ийн оффист зохион байгуулсугай.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
 - “Монгол базальт” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж, батлах
 - “Монгол базальт” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг батлах
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны 03 сарын 31-ний өдрөөр тогтоосугай.
5. “Монгол базальт” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах хурлын зарыг 2023 оны 03 сарын 12-ний өдөр Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас, Компанийн өөрийн цахим болон сошиал хуудас, “Өдрийн сонин” -оор мэдээлсүгэй.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах давтан зарыг 2023 оны 03 сарын 27-ний өдөр анх мэдээлсэн хэлбэрээр мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

7. Хувьцаа эзэмшигч нь энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтад заасан бичиг баримтуудыг 7 хоног бүрийн ажлын өдрүүдийн 11.00-16.00 цагийн хооронд Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, “Фламинго тауэр”-ийн 7 давхарт ирж танилцаж болох ба үйлчлүүлдэг үнэт цаасны компанидаа хандан авах боломжтой болохыг дурьдсугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх материал, энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтад заасан баримт бичгийг бэлэн болгох эцсийн хугацааг 2023 оны 03 сарын 13-ны өдрөөр тогтоосугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудал, хурлаас гаргах тогтоолын төсөл, түүнтэй холбоотой материалыг олон нийтэд хурлын зар хүргэснээс хойш 5 хоногийн дотор хувьцаа эзэмшигч нарт үйлчилж буй Үнэт цаасны компаниудад хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлсүгэй.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг гуравдугаар хавсралтаар баталсугай.
12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ны агуулгыг дөрөвдүгээр хавсралтаар баталсугай.
13. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох “Саналын хуудас”-ны агуулгыг тавдугаар хавсралтаар баталсугай.
14. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох боломжгүй урьдчилан саналын хуудасаар санал өгөх хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг хүлээн авах сүүлийн өдрийг 2023 оны 03 сарын 31-ний өдрийн Баасан гаригийн 18.00 цаг байхаар тогтоосугай.
15. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар А.Энхгэрэл, хурал зохион байгуулах комиссын гишүүдээр О.Билгүүн, Т.Ууганцэцэг нарыг тус тус томилсугай.
16. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын даргаар Б.Болортуяа, тооллогын комиссын гишүүдээр Ц.Мэндбаяр, Б.Амаржаргал нарыг тус тус томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА _____

ГИШҮҮД _____


 _____ Л.Ариунболд

 _____ Г.Ганзориг

 _____ А.Энхгэрэл

 _____ П.Сайнбилэг

 _____ Б.Шаравсамбуу

 _____ Хан Гю Бунг

 _____ Ш.Энхтөр

 _____ Ч.Зоригтбаатар

 _____ П.Нямдорж

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 03 сарын 07-ны өдрийн
04 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАЖ БОЛОХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

№	Баримт бичгийн нэр
1	“Монгол базальт” ХК-ийн ТУЗ-ийн тогтоол Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай 2023.03.07-ны өдрийн Дугаар 04
2	“Монгол базальт” ХК-ийн 2022 оны Санхүүгийн тайлан, Хөндлөнгийн аудитын дүгнэлт
3	“Монгол базальт” ХК-ийн 2022 оны Үйл ажиллагааны тайлан
4	“Монгол базальт” ХК-ийн 2022 оны Үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлийн өгсөн дүгнэлт
5	Компанийн 5-аас дээш хувийн хувьцаа эзэмшигчид, түүний хувьцааны төрөл, тоо
6	Төлөөлөн удирдах зөвлөлийн Ногдол ашиг тараах тухай 2023.02.13-ны өдрийн Дугаар 03 тогтоол
7	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн танилцуулга

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 03 сарын 07-ны өдрийн
04 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт

Зар хүргэх мэдээллийн хэрэгсэл:

1. Хөрөнгийн биржийн цахим сайт www.mse.mn
2. Монгол базальт ХК-ийн цахим сайт www.basaltwool.mn,
3. Facebook page/ Mongol basalt JSC
4. Өдөр тутмын сонин: “Өдрийн сонин”

Зар хүргэх өдөр:

2023 оны 03 сарын 12-ны өдөр, давтан: 2023 оны 03 сарын 27-ны өдөр

“МОНГОЛ БАЗАЛТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

“Монгол базальт” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал **2023** оны **04** сарын **17**-ний өдрийн **Даваа** гаригт **14.00** цагт болох тул Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид та бүхнийг идэвхитэй оролцохыг урьж байна.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал болох газар: Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, “Фламинго тауэр” -ийн 7 давхарт, Монгол базальт ХК-ийн оффист

Хувьцаа эзэмшигч та биечлэн ирж хуралд оролцох боломжгүй тохиолдолд тусгай программ ашиглан цахим хэлбэрээр оролцох бүрэн боломжтой бөгөөд хурал танхим-цахим хосолсон хэлбэрээр хийгдэх болно.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг **2023** оны **03** сарын **31**-ны өдрөөр тасалбар болгоно.

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. “Монгол базальт” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж, батлах
2. “Монгол базальт” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг батлах

Эрхэм хувьцаа эзэмшигч та бүхэн хурлын материалтай өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компани болон Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, “Фламинго тауэр”-ийн 7 давхарт компанийн оффист ажлын өдрүүдэд 11.00-16.00 цагийн хооронд хүрэлцэн ирж танилцах боломжтой.

Дэлгэрэнгүй мэдээллийг 75114444 утсаар авч болно.

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр:	“МОНГОЛ БАЗАЛЫТ” ХК
Хаяг:	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, Үйлдвэрийн баруун бүс, 32 тоот Утас: 75114444
Хурал хуралдах өдөр, цаг:	2023 оны 04 сарын 17-ны өдрийн 14.00 цагт
Хурал хуралдах газар /хаяг, байршил/:	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Фламинго тауэр 7 давхарт, компанийн оффис /танхим болон цахим хосолсон/
Хурлын төрөл:	Ээлжит
Хурал зарлагч:	Төлөөлөн удирдах зөвлөл
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо:	2023 оны 03 сарын 07 өдөр
Олон нийтэд зарлах огноо:	2023 оны 03 сарын 12 өдөр
Бүртгэлийн өдөр:	2023 оны 03 сарын 31 өдөр
Гэрээний дагуу хурлын баримт бичгийг Үнэт цаасны компанид хүргүүлэх огноо:	2023 оны 03 сарын 14 өдөр
Хүргүүлсэн огноо:	2023 оны 03 сарын __ өдөр
Хурлын даргын нэр:	А.Энхгэрэл
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр:	Дарга: Б.Болортуяа Б.Амаржаргал, Ц.Мэндбаяр
Баримт бичгийн жагсаалт /хавсралтаар/:	
Баримт бичгийн хуудасны тоо: ширхэг
 хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА

_____ А.Энхгэрэл

2023 оны 03 дугаар сарын 07-ны өдөр

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДЭГ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг “Монгол базальт” ХК-ийн оффист хийнэ.

Эрхэм хувьцаа эзэмшигч та хүрэлцэн ирж хуралдаа оролцоно уу.

Хувьцаа эзэмшигчдийн хурал дараах дараалалаар явагдана. Үүнд:

- | | |
|---|----------|
| 1. Хувьцаа эзэмшигчдийн ирцийн бүртгэл, ирцийг мэдээлэх | 15 минут |
| 2. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг нээх
Хурлын дарга А.Энхгэрэл | 10 минут |
| 3. Хурлаар хэлэлцэх асуудлын дагуу илтгэл тавина | |
| 3.1 Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн
тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлт,
хурлаас гарах тогтоолын төслийг танилцуулах | 15 минут |
| 4. Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт, хариулт | 5 минут |
| 5. Хөндлөнгийн аудитын компаниас асуулт асуух, хариулт авах | 5 минут |
| 6. Төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшигчдийн танилцуулга | 15 минут |
| 7. Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт, хариулт | 5 минут |
| 8. Төлөөлөн удирдах зөвлөлийн цалин, урамшуулал төсөл танилцуулах | 10 минут |
| 9. Хэлэлцэж буй асуудлаар асуулт, хариулт | 5 минут |
| 10. Нийт хэлэлцэж буй асуудлаар санал шүүмжлэл сонсох | 10 минут |
| 11. Санал авах /цахим болон саналын хуудасаар/ | 15 минут |
| 12. Санал хураалтын дүнг нэгтгэн, танилцуулах | 5 минут |
| 13. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан шийдвэрийг
танилцуулж, хурал хаах | 5 минут |

Хурлын дарга _____ А.Энхгэрэл



Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 03 сарын 07-ны өдрийн
04 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралт

“МОНГОЛ БАЗАЛТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС

Санал хураах арга: Энгийн

Хувьцаа эзэмшигчийн овог: _____

Хувьцаа эзэмшигчийн нэр: _____

Регистрийн дугаар: _____

Итгэмжлэгдсэн төлөөлөгч оролцож байгаа тохиолдолд

Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог, нэр _____

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

Брокерийн компанийн нэр: _____

“Монгол базальт” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 04 сарын 17-ны өдрийн Даваа гаригийн 14.00 цагт

№	Хэлэлцэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах			
2	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг батлах			

Хувьцаа эзэмшигч /итгэмжлэгдсэн төлөөлөгч/-ийн гарын үсэг _____ /
Санал авах хуудас үйлдсэн: 2023 оны ___ сарын ___ өдөр

Саналын хуудасыг хүчинтэйд тооцсон эсэх: _____

Тооллогын комиссын дарга _____ /Б.Болортуяа/

Саналын хуудасыг хүчингүйд тооцсон шалтгаан: _____

Санамж:

1. Хувьцаа эзэмшигч нь саналын хуудасыг бөглөхдөө санал өгөх хэсэгтээ +/- тэмдэглэгээ хийнэ. Жишээ нь: Зөвшөөрсөн бол зөвшөөрсөн хүснэгтэд +/- тэмдэглэгээ хийнэ.
2. Санал авах хуудасны эхний хэсгийг зуучлагч үнэт цаасны компанийн тэмдэг даран баталгаажуулж хувьцаа эзэмшигчдэд өгнө.
3. Засварласан, балласан залруулагатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
4. Хувьцаа эзэмшигчид нь 2023 оны 03 сарын 31-ний дотор хурлын материалтай танилцах бөгөөд өөрийн биеэр оролцох боломжгүй тохиолдолд 2023 оны 03 сарын 31-ний 18.00 цагаас өмнө санал авах хуудсанд саналаа тэмдэглэн үйлчлүүлдэг үнэт цаасны компанидаа хүргүүлнэ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 03 сарын 07-ны өдрийн
04 дүгээр тогтоолын тавдугаар хавсралт

**“МОНГОЛ БАЗАЛТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС**

Санал хураах арга: Кумулятив

Хувьцаа эзэмшигчийн овог: _____

Хувьцаа эзэмшигчийн нэр: _____

Регистрийн дугаар: _____

Итгэмжлэгдсэн төлөөлөгч оролцож байгаа тохиолдолд

Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог, нэр _____

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

Брокерийн компанийн нэр: _____

“Монгол базальт” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 04 сарын 17-ны өдрийн Даваа гаригийн 11.00 цагт

№	Хэлэлцэх асуудал	ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч	Саналын эрхийн тоо
1	ТУЗ-ийн ердийн гишүүнийг сонгох	Л.Ариунболд	
		П.Сайнбилэг	
		А.Энхгэрэл	
		Г.Ганзориг	
		Б.Шаравсамбуу	
		Хан Хю Бунг	
2	ТУЗ-ийн хараат бус гишүүнийг сонгох	П.Нямдорж	
		Ч.Зоригтбаатар	
		Ш.Энхтөр	
	Саналын эрхийн тоо		

Кумулятив аргаар санал хураах жишээ:

Тус арга нь санал өгөх эрхийн нийт тоо таны эзэмшиж байгаа саналын эрхтэй энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна. Жишээ нь: Та 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг гэвэл ТУЗ нь 9 гишүүнтэй байхад 100 ширхэг энгийн хувьцаа нь 900 саналын эрхтэй /100*9=900/ болох бөгөөд 600 саналын эрхээр ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид санал өгөх, 300 саналын эрхээр ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид санал өгөх эрхтэй болно.

Хувьцаа эзэмшигч /итгэмжлэгдсэн төлөөлөгч/-ийн гарын үсэг _____ /

Санал авах хуудас үйлдсэн: 2023 оны ___ сарын ___ өдөр

Саналын хуудасыг хүчинтэйд тооцсон эсэх: _____

Тооллогын комиссын дарга _____ /Б.Болортуяа/

Саналын хуудасыг хүчингүйд тооцсон шалтгаан: _____

Санамж:

- Хувьцаа эзэмшигч нь саналын хуудасыг бөглөхдөө санал өгөх хэсэгтээ +/- тэмдэглэгээ хийнэ. Жишээ нь: Зөвшөөрсөн бол зөвшөөрсөн хүснэгтэд +/- тэмдэглэгээ хийнэ.
- Санал авах хуудасны эхний хэсгийг зуучлагч үнэт цаасны компанийн тэмдэг даран баталгаажуулж хувьцаа эзэмшигчдэд өгнө.
- Засварласан, балласан залруулагатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
- Хувьцаа эзэмшигчид нь 2023 оны 03 сарын 31-ны дотор хурлын материалтай танилцах бөгөөд өөрийн биеэр оролцох боломжгүй тохиолдолд 2023 оны 03 сарын 31-ны 18.00 цагаас өмнө санал авах хуудсанд саналаа тэмдэглэн үйлчлүүлдэг үнэт цаасны компанидаа хүргүүлнэ.